

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ЭНГИЙН ХУВЬЦАА НЭМЖ ГАРГАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.1, 55 дугаар зүйлийн 55.2, 55.3, 76 дугаар зүйлийн 76.1, 76.1.4, 76.1.6, 87 дугаар зүйлийн 87.1.2 заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9.2.12.12, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2020 оны 11 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 дүгээр тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компани нэг бүр нь 19 төгрөгийн үнэ бүхий 134,953,581 ширхэг, энгийн хувьцааг, хаалттай хүрээнд нэмж гаргасугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар тогтоосныг дурдсугай.
3. Компанийн нэмж гаргаж буй хувьцаа нь компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохгүй тул хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх шаардлага үүсэхгүй болохыг дурдсугай.
4. Хаалттай хүрээнд энгийн хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хөрөнгө нэмэгдэж, гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт орох тул тус өөрчлөлтийг компанийн дүрэмд тусган холбогдох газруудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Золжаргалд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ